

1

ЭДИЙН ЗАСГИЙН БҮТЦИЙГ ӨӨРЧЛӨХ ГОЛ АРГА ЗАМ БОЛ ИННОВАЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЯВДАЛ МӨН

Д.Моломжамц

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тойм

Монгол улс 1940 – өөд оноос аж ахуй, соёлыг хөгжүүлэх жил жилийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байгаад 1946 оноос Улс Ардын Аж Ахуйг (УААА) хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөөний үндсэн дээр улс орны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг төлөвлөж хэрэгжүүлж ирсэн байна. Энэ талаар Монгол улсын түүх бичигт “...1946 оны IX сард Намын Төв Хорооны Улс төрийн Товчоо БНМАУ–ын УААА ба соёл, боловсролыг хөгжүүлэх анхдугаар таван жилийн төлөвлөгөө зохиох тухай тогтоол гаргав”¹ гэсэн байна.

Улмаар 1950 – иад оноос социалист хамтын нөхөрлөлийн орнууд буй болж манай улс ЭЗХТЗ–ийн гишүүн орон болсноор эдийн засгийн интеграцид нэгдэн орж социалист орнуудтай өөрийн УААА–г хөгжүүлэх төлөвлөгөөг нягт уялдуулж ирсэн юм. Үүний дагуу ялангуяа хуучин ЗХУ болон социалист бусад орнуудаас ихээхэн хэмжээний зээл тусламжийг авч төсвийн алдагдлыг нөхөж ирсэн бөгөөд тухайн үед улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрт энэ нь чухал байр суурь эзэлж байжээ.

Социализмын үеийн Монгол улсын эдийн засгийн болон хөрөнгө оруулалтын хэмжээ, өсөлтийн хурдцыг 1960 оноос эхлэн авч үзэх нь илүү зохимжтой гэж үздэг. Учир нь Монгол оронд 1921 онд Ардын хувьсгал ялж ЗХУ–ын тусламжтайгаар аж үйлдвэрийн суурь элементүүдийг буй болгож эхэлсэн ч 1960–аад он хүртэл улс орны эдийн засаг, аж ахуйн цар хэмжээ харьцангуй бага байсан юм.

Харин 1960 – аад оноос манай улсын эдийн засгийн бодит салбарууд, түүний дотор аж үйлдвэр эрчимтэй хөгжиж эхэлснээр үндэсний орлого,

дотоодын нийт бүтээгдэхүүн нэмэгдэн санхүүгийн нөөц буй болж улс орны амьдралд бодитойгоор нөлөөлөх болсон байна.

¹ Монгол улсын түүх. Тавдугаар боть. Ред. Ж.Болдбаатар, М.Санждорж, Б.Ширэндэв. УБ, 2003. 261-р тал

Академич Т.Намжимын тэмдэглэснээр "...1940 оны үед эдийн засагт шинээр оруулсан хөрөнгийн хэмжээг 1990 оны үетэй харьцуулвал харьцангуй хомс байжээ. Монгол улсын эдийн засгийн өсөлт, цар хэмжээ 1960 оны үе гэхэд 1940 оныхоос олон дахин нэмэгдсэн байлаа"² гэсэн байна. Социализмын үед улс, хоршоолол, гадаад оронтой хамтарсан буюу хувь нийлүүлсэн гэсэн өмчийн гурван төрөл зонхилж байсан хэдий ч эдийн засагт үндсэндээ улсын хөрөнгө оруулалт давамгайлж байсан юм. Манай улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд ахиц гарч үндэсний орлогын жилийн дундаж өсөлт 1961 – 1965 онд 1.1 хувь, 1966 – 1970 онд 3.4 хувь, 1971 – 1975 онд 6.0 хувь болж нэмэгдсэний үр дүнд нийгмийн хэрэглээ, хуримтлалын зохистой түвшинд хүрч хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх боломж буй болсон байна.

Эдийн засагт оруулсан нийт хөрөнгө оруулалт тухайн үеийн үнэ ханшаар тооцоход 1971 – 1975 онд 7 тэрбум, 1976 – 1980 онд 15 тэрбум, 1981 – 1985 онд 22 тэрбум, 1986 – 1990 онд 24 тэрбум төгрөгт хүрч тогтвортойгоор өсөн нэмэгдэж байсан.³ Энэ нь улс орны эдийн засгийн өсөлтийг бий болгох материаллаг орчинг бүрдүүлж, үндэсний орлогын үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлтийг нэмэгдүүлсэн юм.

Харин Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлснээс хойшхи хугацаанд өмчийн олон хэлбэрийг албан ёсоор хүлээн зөвшөөрч, дэлхийн олон улсад нээлттэй бодлогыг явуулж, олон улсын банк санхүүгийн байгууллагад элссэнээр төсвийн хөрөнгө оруулалтын зэрэгцээ шинээр хувийн хөрөнгө оруулалт буй болсон, түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж эдгээрийн улс орны нийгэм - эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдэж байна.

Гэхдээ хөрөнгө оруулалтын бүтцийн бодлогыг хэрэгжүүлэх, улс орны дэд бүтцийг хөгжүүлэх, хувийн бизнес болон гадаадын хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, нэмэгдүүлэхэд төсвийн хөрөнгө оруулалт чухал үүрэгтэй хэвээр байна. Тиймээс Монгол улсын хөгжилд тэргүүлэх ач холбогдол бүхий эдийн засгийн салбарыг дэмжих, инновацийг нэвтрүүлэх, эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтыг цаашид нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм.

Монгол улс зах зээлд шилжиж эхэлсэн 1990 оноос хойшхи сүүлийн 20 жилд хөрөнгө оруулалтын бүтцэд ихээхэн өөрчлөлт гарсаны зэрэгцээ хөрөнгө оруулалтын нийт хэмжээ олон дахин нэмэгдсэн байна. (Хүснэгт № 1)

² Т.Намжим “Монголын аж ахуй эдийн засаг : түүхэн гурван үед” УБ, 2000. 593, 594-р тал

³ Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн судалгаа. УБ, 2000. 4-р тал

Монгол улсын хөрөнгө оруулалтын бүтэц, санхүүжилтийн эх үүсвэрээр
(1990-2010) /оны үнээр, тэрбум төгрөгөөр/

| Үзүүлэлт | Хүснэгт № 1 | | | | |
|-------------------------------------|-------------|------|-------|-------|--------|
| | 1990 | 1995 | 2000 | 2005 | 2009* |
| Хөрөнгө оруулалт оны үнээр, бүгд | 3.4 | 91.5 | 284.7 | 797.1 | 1943.2 |
| Үүнээс санхүүжилтийн эх үүсвэрээр : | | | | | |
| Төсвийн хөрөнгө, бүгд | 1.2 | 13.2 | 36.3 | 64.8 | 431.6 |
| Төсвийн бус хөрөнгө, бүгд | 2.2 | 78.3 | 248.4 | 732.3 | 1511.6 |

*Урьдчилсан гүйцэтгэл

Эх үүсвэр :

1. “Монгол улс зах зээлд статистикийн эмхтгэл 1989 – 2002” УБ, 2004. 137-р тал
2. “Монгол улсын статистикийн эмхтгэл 2006” УБ, 2007. 165-р тал
3. “Монгол улсын статистикийн эмхтгэл 2009” УБ, 2010. 185-р тал

Дээрх тоо мэдээнээс үзвэл Монгол улсын нийт хөрөнгө оруулалтын хэмжээ тус улс зах зээлд шилжсэн сүүлийн 20 жилд олон дахин нэмэгдэж 1990 онд 3.4 тэрбум төгрөг байсан бол 2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1943.2 тэрбум төгрөг болсон байна. Статистикийн энэхүү тоо мэдээ нь оны үнээр илэрхийлэгдсэнтэй уялдан түүнд төгрөгийн ханшны өөрчлөлт ихээхэн нөлөөлсөн нь тодорхой хэдий ч хөрөнгө оруулалтын хэмжээ зах зээлийн шилжилтийн эхэн үеийн эдийн засгийн хүндрэл бэрхшээлтэй үеэс эдийн засаг тогтворжиж, улмаар өсөлт ажиглагдсан сүүлийн жилүүдэд олон дахин нэмэгдсэнийг харуулж байна.

2. Судалгаа, боловсруулалтын ажилд зарцуулж буй хувийн секторын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлага

Хөрөнгө оруулалтын хэмжээ ингэж олон дахин нэмэгдсэн байхад 1990 оноос хойшхи сүүлийн 20 жилд Монгол улсын аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийн салбарын бүтцэд уул уурхай, олборлох үйлдвэрийн хувийн жин давамгайлсан хэвээр, боловсруулах үйлдвэрийн хувийн жин ерөнхийдөө буурах хандлагатай, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн хувийн жин бараг тогтмол байсан байна. Өөрөөр хэлбэл дээрх хугацаанд манай улсын эдийн засгийн бүтцэд эерэг өөрчлөлт бараг гараагүй гэж хэлж болохоор байна. (Хүснэгт № 2)

Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийн салбарын бүтэц, оны үнээр /Хүснэгт № 2/

| Үзүүлэлт | 1990 | 1995 | 2000 | 2005 | 2009* |
|---|------|------|------|------|-------|
| Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл | 100 | 100 | 100 | 100 | 100 |
| Уул уурхай, олборлох үйлдвэр | 16.1 | 51.4 | 51.7 | 66.8 | 57.8 |
| Боловсруулах үйлдвэр | 71.8 | 34.4 | 32.4 | 20.5 | 32.1 |
| Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж | 12.1 | 14.3 | 15.9 | 12.8 | 10.1 |

*Урьдчилсан гүйцэтгэл

Эх үүсвэр :

1. “Монгол улс зах зээлд статистикийн эмхтгэл 1989 – 2002” УБ, 2003. 188, 189-р тал
2. “Монгол улсын статистикийн эмхтгэл 2006” УБ, 2007. 126, 214-р тал
3. “Монгол улсын статистикийн эмхтгэл 2009” УБ, 2010. 236-р тал

Энэ нь орчин үеийн техник технологи бүхий жижиг, дунд үйлдвэрүүдийг байгуулж, ажлын байрыг шинээр буй болгох, өөрөөр хэлбэл боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд зориулсан хөрөнгө оруулалтын хэмжээ хангалтгүй байгааг харуулж байна.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед Монгол улс боловсруулах үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхэд ихээхэн анхаарч байсан. Тэр үед ялангуяа малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрүүдийг олноор байгуулсан нь дэвшилттэй байсан хэдий ч тэдгээрийн цөөнгүй хэсгийг “хүчээр” (тэр үед алдагдалтай ажиллаж байсан зарим үйлдвэрт салбарын хэмжээнд ашигтай ажиллаж байсан үйлдвэрийн ашгаас тэгшитгэн хуваарилаж, улмаар улсаас татаас олгох замаар алдагдлыг нь нөхөн ажиллуулж байв) ажиллуулж байсантай холбоотойгоор зах зээлийн эхэн үед буюу 1990 онд нийт аж үйлдвэрийн салбарт эзлэх боловсруулах үйлдвэрийн хувийн жин өндөр байсан. Харин үүний дараа өмч хувьчлал явагдаж боловсруулах үйлдвэрүүд хувьд шилжсэнээр зах зээлийн зарчмаар зарим нь дампуурч, хөрөнгө санхүүгийн хүндрэл бэрхшээл, түүхий эд, ажиллах хүчний хомсдолтой байдал зэрэг шалтгаанаар ихэнх үйлдвэрүүд үүд хаалгаа барьсанаар аж үйлдвэрийн салбарт уул уурхай, олборлох үйлдвэрийн хувийн жин давамгайлж эхэлсэн. Энэ байдал сүүлийн жилүүдэд “Оюу толгой”, “Таван толгой” зэрэг уул уурхайн том ордуудыг ашиглаж эхэлсэнтэй уялдан цаашид ч үргэлжлэх төлөвтэй байна.

Харин уул уурхайн эдгээр томоохон төслүүдээс Монгол улсын төсөвт орж ирж байгаа их хэмжээний санхүүгийн эх үүсвэрийг ард түмэнд бэлэн мөнгө тараах хэлбэрээр үр ашиггүй зарцуулах бус улс орны эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх, түүхий эдийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх орчин үеийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж экспортыг нэмэгдүүлэхэд зориулах шаардлагатай байна.

1990 оноос хойш сүүлийн 20 жилд Монгол улсын экспортод гаргаж буй гол нэр төрлийн бүтээгдэхүүгийн нийт экспортын дүнд эзэлж буй хувийн жин, бүтцэд мөн дорвитой өөрчлөлт ороогүй байгаа нь эдийн засгийн бүтцийн өөрчлөлт ихээхэн удаашралтай байгааг харуулж байна. (Хүснэгт № 3)

Монгол улсын экспортод гаргаж буй ТОП-5 нэр төрлийн бүтээгдэхүүн (1990-2009)

| 1990 (1992) | | | 1995 | | |
|-------------|---|------|------|---|------|
| | Нэр төрөл | % | | Нэр төрөл | % |
| 1. | Эрдэс бүтээгдэхүүн | 50.2 | 1. | Эрдэс бүтээгдэхүүн | 65.5 |
| 2. | Нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн | 21.4 | 2. | Нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн | 17.1 |
| 3. | Түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл | 8.6 | 3. | Түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл | 5.0 |
| 4. | Мал амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн | 5.7 | 4. | Үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүн | 3.6 |
| 5. | Ургамлын гаралтай бүтээгдэхүүн | 4.2 | 5. | Мал амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн | 2.2 |

| 2000 | | | 2005 | | |
|-----------|---|------|-----------|---|------|
| Нэр төрөл | | % | Нэр төрөл | | % |
| 1. | Нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн | 35.9 | 1. | Эрдэс бүтээгдэхүүн | 42.7 |
| 2. | Эрдэс бүтээгдэхүүн | 35.2 | 2. | Үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлс | 31.1 |
| 3. | Үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлс | 14.1 | 3. | Нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн | 18.0 |
| 4. | Түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл | 7.9 | 4. | Түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл | 2.9 |
| 5. | Мал амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн | 4.3 | 5. | Мал амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн | 1.8 |

| 2009 | | |
|-----------|---|------|
| Нэр төрөл | | % |
| 1. | Эрдэс бүтээгдэхүүн | 66.4 |
| 2. | Үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлс | 16.4 |
| 3. | Нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн | 10.2 |
| 4. | Мал амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн | 2.4 |
| 5. | Түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл | 1.5 |

Эх үүсвэр :

1. “Монгол улс зах зээлд статистикийн эмхтгэл 1989 – 2002” УБ, 2004. 227-р тал
2. “Монгол улсын статистикийн эмхтгэл 2006” УБ, 2007. 249-р тал
3. “Монгол улсын статистикийн эмхтгэл 2009” УБ, 2010. 269-р тал

Тухайлбал дээрх хугацаанд манай улсын экспортод хамгийн их хувийн жин эзэлж байгаа 5 нэр төрлийн бүтээгдэхүүгийнг авч үзэхэд Эрдэс бүтээгдэхүүн ; Нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн ; Түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл ; Мал амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн гэсэн 4 нэр төрлийн бүтээгдэхүүн тогтмол өндөр хувийн жин эзэлсээр иржээ. Дээрх хугацаанд экспортын гол 5 нэр төрлийн бүтээгдэхүүнд бага зэргийн өөрчлөлт орсон байна. Тухайлбал, 1990 онд ургамлын гаралтай бүтээгдэхүүн, 1995 онд үндсэн төмөрлөг зэрэг бүтээгдэхүүн эхний 5-д орж байсан бол 2000 оноос эдгээрийн оронд үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлсийн экспорт тодорхой хувийг эзлэх болсон байна.

Экспортын эдгээр гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүд нь үндсэндээ анхан шатны боловсруулалт хийгдсэн уул уурхай, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд байгаа юм. Тиймээс манай улс орчин үеийн техник технологи ашиглаж үйлдвэрлэсэн, оюуны багтаамж өндөртэй, дэлхийн зах зээлд өрсөлдөхүйц эцсийн бүтээгдэхүүгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хөрөнгө оруулалтын бодлогыг улс орноо эрчимтэй аж үйлдвэржүүлэхэд шууд чиглүүлэн эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг асар богино хугацаанд хийсэн БНСУ – ын туршлагыг судлан зарим тоо мэдээг Монгол улсын эдийн засгийн холбогдох үзүүлэлтүүдтэй харьцуулан дүгнэлт өгсөн юм. Ингэхдээ манай хоёр улсын эдийн засгийн хөгжлийн түвшний бодит ялгааг харгалзан үзэхийн зэрэгцээ харьцуулалтыг бодитой, үр дүнтэй болгох үүднээс Солонгосын дайны дараах үе буюу 1960 - аад оны эхэн үеийн БНСУ - ын эдийн засгийн хүнд үеийг зах зээлийн шилжилтийн эхэн үе буюу 1990 - ээд оны Монгол улсын эдийн засгийн хүндрэл бэрхшээлтэй үетэй дүйцүүлэн харьцуулж эдийн засагт гарсан өөрчлөлтийг дүгнэхийг зорьсон болно.

Тус улс Дэлхийн II дайны дараа Хойд болон Өмнөд гэсэн хоёр хэсэгт хуваагдахад байгалийн гол нөөц баялаг, хүнд аж үйлдвэрийн салбар нь Хойд Солонгосын нутаг дэвсгэрт, харин цөөн тооны хөнгөн үйлдвэр болон хөдөө аж ахуйн салбар нь Өмнөд Солонгосын нутаг дэвсгэрт үлдсэн байна. Гэвч 1960 онд засгийн эрхэнд гарсан генерал Пак Чон Хи-гийн Засгийн газар тус улсыг 1962 оноос эхлэн 5 жилийн төлөвлөгөөтэйгөөр эрчимтэй хөгжүүлэх зорилт тавин ажиллаж эхэлжээ.

Эхний жилүүдэд импортыг орлох бүтээгдэхүүгийн үйлдвэрлэлийг түлхүү дэмжиж байсан бол 1964 оноос экспортыг дэмжих зорилгоор “Нэгдүгээрт экспорт” бодлогыг явуулж эхэлсэн. Ялангуяа 1974 онд (гуравдугаар 5 жилийн төлөвлөгөөний үе) Хүнд ба химийн аж үйлдвэрлэлийг дэмжих төлөвлөгөөний хүрээнд “Үндэсний хөрөнгө оруулалтын сан”-г үүсгэн байгуулсан нь усан онгоц, машин барилга, гангийн үйлдвэрлэл, газрын тосны бүтээгдэхүүн болон химийн бусад үйлдвэрлэлийг амжилттай хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна...

БНСУ – ын экспортын гол 5 нэр төрлийн бүтээгдэхүүгийн авч үзвэл Солонгосын дайны дараа аж үйлдвэр дөнгөж сэргэж эхэлж байсан 1960 – аад оны эхэн үед тус улсын экспортод төмрийн хүдэр, вольфрам, түүхий торго, антрацит буюу жинд нүүрс, өгөөшний загас зэрэг уул уурхай, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн зонхилж байсан нь зах зээлийн шилжилтийн эхэн үе буюу 1990 - ээд оны эхэн үеийн Монгол улсын экспортын бүтэцтэй адил төстэй байна. Харин 20 жилийн дараа буюу 1980 он гэхэд тус улсын экспортод нэхмэл бүтээгдэхүүн, цахилгаан бараа, төмөр болон гангийн бүтээгдэхүүн, оймс гутал, усан онгоц зэрэг бүтээгдэхүүн гол хувийн жин эзлэх болсон нь экспортын бүтцэд эрс өөрчлөлт орсныг харуулж байна. Өөрөөр хэлбэл 20 жилийн хугацаанд экспортын тэргүүлэх 5 нэр төрлийн бүтээгдэхүүн бүгд өөрчлөгджээ. (Хүснэгт № 4)

БНСУ-ын экспортод гаргаж буй ТОП-5 нэр төрлийн бүтээгдэхүүн (1960-2007)

Хүснэгт № 4

| 1960 | | | 1970 | | |
|-----------|-----------------------|------|-----------|-----------------|------|
| Нэр төрөл | | % | Нэр төрөл | | % |
| 1. | Төмрийн хүдэр | 13.0 | 1. | Нэхмэл | 40.8 |
| 2. | Вольфрам | 12.6 | 2. | Наамал хавтан | 11.0 |
| 3. | Түүхий торго | 6.7 | 3. | Хиймэл үс | 10.8 |
| 4. | Антрацит (жинд нүүрс) | 5.8 | 4. | Төмрийн хүдэр | 5.9 |
| 5. | Өгөөшний загас | 5.5 | 5. | Цахилгаан бараа | 3.5 |

| 1980 | | | 1990 | | |
|-----------|----------------------------------|------|-----------|-------------------------|------|
| Нэр төрөл | | % | Нэр төрөл | | % |
| 1. | Нэхмэл | 28.8 | 1. | Нэхмэл бүтээгдэхүүн | 11.7 |
| 2. | Цахилгаан бараа | 11.4 | 2. | Хагас дамжуулагч | 7.2 |
| 3. | Төмөр болон гангийн бүтээгдэхүүн | 9.0 | 3. | Оймс, гутал | 4.6 |
| 4. | Оймс, гутал | 5.2 | 4. | Усан онгоц | 4.3 |
| 5. | Усан онгоц | 3.5 | 5. | Телевизор, видео техник | 4.1 |

| 2000 | | | 2007 | | |
|-----------|----------------------------------|------|-----------|----------------------------------|------|
| Нэр төрөл | | % | Нэр төрөл | | % |
| 1. | Хагас дамжуулагч | 15.1 | 1. | Хагас дамжуулагч | 10.5 |
| 2. | Компьютер | 8.4 | 2. | Автомашин | 10.0 |
| 3. | Автомашин | 7.7 | 3. | Утасгүй холбооны тоног төхөөрөмж | 8.2 |
| 4. | Газрын тосны бүтээгдэхүүн | 5.5 | 4. | Усан онгоц | 7.5 |
| 5. | Утасгүй холбооны тоног төхөөрөмж | 4.8 | 5. | Газрын тосны бүтээгдэхүүн | 6.4 |

Эх үүсвэр : The Korea International Trade Association, each year, Seoul. 2009.

Түүнчлэн 10 жилийн дараа буюу 1990 онд тус улсын экспортод нэхмэл бүтээгдэхүүн, хагас дамжуулагч, оймс гутал, усан онгоц, телевизор - видео техник хэрэгсэл зэрэг бүтээгдэхүүн гол хувийн жин эзэлж байсан бол 2000 онд хагас дамжуулагч, компьютер, автомашин, газрын тосны бүтээгдэхүүн, утасгүй холбооны тоног төхөөрөмж, 2007 оны байдлаар эдгээрээс гадна хавтгай дэлгэцийн флатын экспорт нэмэгдсэн зэрэг нь тус улсын шинжлэх ухаан, техник технологи, инновацийн ололт амжилтыг харуулахын зэрэгцээ аж үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж улс орныхоо эдийн засгийн бүтцийг эрс өөрчилж байгааг илтгэж байна.

Манай улсын эдийн засагт хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн болон байгалийн баялагийн олзворлолт бүхий уул уурхайн салбарын үйлдвэрлэл зонхилж байна. Иймээс Монгол улс ойрын жилүүдэд нэн яаралтай өөрийн улсын брэнд болсон, орчин үеийн стандарт шаардлагыг хангасан эцсийн

бүтээгдэхүүгийн үйлдвэрлэлийг эрс нэмэгдүүлж экспортын бүтцийг сайжруулах шаардлагатай байгаа нь БНСУ-ын туршлагаас харагдаж байна.

Засгийн Газрын 2007 оны 306 тоот тогтоолоор баталсан “Монгол улсад Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр 2008 – 2015” -д “Дэвшилтэт технологийг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг баталсан билээ. Энэ хөтөлбөрт “Дэвшилтэт технологийг физик, хими, молекул биологи, электроник зэрэг олон шинжлэх ухааны уулзвар дээр бий болон хөгжиж байгаа нанотехнологи, биотехнологи, мэдээлэл, харилцаа холбооны технологи, сансрын технологи, робот, автоматжуулалтын технологи зэрэг орчин үеийн шинэ чиглэлүүд юм” гэж тодорхойлсон байна. Эдгээрээс манай улсад :

- Биотехнологи ;
- Мэдээлэл, харилцаа холбооны технологи ;
- Нано технологи зэрэг орчин үеийн технологиудыг хөгжих боломжтой гэж үзээд тус бүрийн зорилт, хэрэгжүүлэх үе шат, үр дүн, санхүүжилтийн асуудлыг тодорхойлжээ.

Түүнчлэн :

“Биотехнологийн гол зорилт :

Биотехнологийн салбарт орчин үеийн биотехнологийн үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж, хүн амын эрүүл мэнд, хүнсний хангамжийг сайжруулан, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, байгаль орчин, уул уурхайн салбарт биотехнологийн ололтыг нэвтрүүлж, бүс нутгийн хэмжээнд өрсөлдөх чадварыг бий болгоно.

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн гол зорилт :

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт судалгаа шинжилгээний чадавхийг сайжруулж, мэдээлэл харилцаа холбооны технологийг оюуны үйлдвэрлэл болгон хөгжүүлнэ.

Нано технологийн гол зорилт :

Нанотехнологийн салбарт шинэ мэдлэг, шинэ арга технологийг хөгжүүлэн технологийн агууламж өндөртэй, аюулгүй нано бүтээгдэхүүгийг гаргаж, үндэсний нано-үйлдвэрлэлийг бий болгоно” гэж заасан байна.

Бид улс орны хэмжээнд дээрх тэргүүлэх салбарыг эрчимтэй хөгжүүлэхийн тулд орчин үеийн техник технологийг импортлох, дотооддоо шинжлэх ухааны судалгааг хөгжүүлэх, чадварлаг боловсон хүчнийг бэлтгэхэд зориулж буй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах шаардлагатай болж байна.

Манай улсын экспортод гаргаж буй бүтээгдэхүүгийн технологийн агууламжийн түвшинг авч үзвэл тун хангалтгүй үр дүн харагдаж байна. Түүхий эдийн нөөцийг боловсруулан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх техник технологийн түвшин хангалтгүй, эдийн засгийн чадавхи сул байгаагаас манай улсын экспортод технологийн багтаамжгүй бүтээгдэхүүн, нам технологит бүтээгдэхүүн дийлэнх хувийг эзэлж байна. Үүнийг технологийн агууламжийн

хувиар илэрхийлсэн экспортын бүтцийн дараах үзүүлэлтүүдээс харж болно.
(Хүснэгт № 5)

Экспортын бүтэц (технологийн агууламжийн хувиар)

Хүснэгт № 5

| Үзүүлэлтүүд | 1999 | 2000 | 2001 | 2002 | 2003 |
|--------------------------------------|-------|-------|-------|-------|-------|
| Технологийн багтаамжгүй бүтээгдэхүүн | 41.72 | 45.03 | 46.81 | 45.26 | 44.93 |
| Нам технологит бүтээгдэхүүн | 53.98 | 52.87 | 50.89 | 53.44 | 52.77 |
| Дундаж доод технологит бүтээгдэхүүн | 1.8 | 1.4 | 1.0 | 0.8 | 1.5 |
| Дундаж өндөр технологит бүтээгдэхүүн | 2.4 | 0.4 | 1.3 | 0.5 | 0.8 |
| Өндөр технологит бүтээгдэхүүн | 0.1 | 0.1 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Нийт экспорт | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |

Эх үүсвэр :

1. “Монгол улсын шинжлэх ухаан технологийн салбарын нэгдсэн үнэлгээ” БСШУЯ, УБ, 2006. 15-р тал

Дээрх хүснэгтээс үзвэл манай улсын экспортын бүтээгдэхүүгийн дийлэнх хэсэг буюу 95 – 98 орчим хувийг технологийн багтаамжгүй буюу нам технологит бүтээгдэхүүн эзэлж байна. Өөрөөр хэлбэл манай улс үндсэндээ ямар нэг боловсруулалт хийгээгүй түүхий эдийг экспортод гаргаж байна гэсэн үг юм. Тиймээс бид шинжлэх ухааны багтаамж бүхий эдийн засгийн салбарыг хөгжүүлэх бааз суурь болсон аж үйлдвэрийн шинэ техник технологи, инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, дэмжих чиглэлээр ирээдүйг харсан, цэгцтэй бодлого, хөтөлбөр боловсруулж ажиллах шаардлагатай байна.

Манай улсын инновацийн хөгжлийн өнөөгийн байдлыг тоймлон авч үзвэл :

- Инновацийн далайцтай бодлого байхгүй ;
- Үндэсний инновацийн оновчтой тогтолцоо, механизм бүрдээгүй ;
- Инновацийн хэрэгжилтийн үр дүн хангалтгүй ;
- Хувийн хэвшлийн инновацийн потенциал сул ;
- Шинжлэх ухаан-Боловсрол-Бизнесийн үйл ажиллагааны уялдаа холбоо сул, хамтын ажиллагаа хангалтгүй ;
- Инновацийн санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгө дутмаг зэргээр товч тодорхойлж болно.

Тиймээс бид юуны өмнө :

- Улсын хэмжээнд инновацийн үйл ажиллагаан дахь бэрхшээлүүдийг тодорхойлох ;

- Инновацийн талаарх төр засгийн дэмжлэг, үүрэг функц, механизмыг тодорхойлох ;
- Хөрөнгө оруулалтын төсөл ба эрдэм шинжилгээ – судалгааны хэрэгцээ, тэдгээрийн хоорондын холбоо хамаарлыг сайжруулах ;
- Улсын төсвөөс санхүүжүүлсэн эрдэм шинжилгээний төслүүдийг үйлдвэрлэлд шууд нэвтрүүлэх, шалгуур үзүүлэлтүүдийг боловсронгуй болгох, төслийн үр ашгийг бодитойгоор үнэлэх ;
- Томоохон аж ахуйн нэгж, пүүс компаниудын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих, урамшуулах зэрэг ажлуудыг нэн яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Манай улс зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлснээс хойш хэсэг хугацаанд шинжлэх ухаан техник, технологийн судалгаа шинжилгээний ажил зогсонги байдалд орсон гэж хэлж болно. Манай пүүс, компаниуд санхүүгийн хувьд бэхжиж чадаагүй, эдийн засгийн чадавхи харьцангуй сул байгаа тул инновацийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулахаас илүүтэйгээр анхдагч капиталыг бүрдүүлэх, капиталын хуримтлалыг буй болгохыг сонирхож байгаа юм.

Нөгөө талаас эрдэм шинжилгээ судалгааны ажлыг зөвхөн их сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдэд хариуцуулж тэдгээрийг улсын төсвөөс санхүүжүүлэх нь үр ашиг багатай болох нь харагдаж байна. Тиймээс ялангуяа томоохон пүүс компаниудын инновацийн үйл ажиллагааг дэмжих, тэдгээрийн эрдэм шинжилгээ, судалгаа боловсруулалтын ажлыг нэмэгдүүлэхтэй холбогдсон хөрөнгө оруулалтыг урамшуулах, эдгээртэй холбогдсон эдийн засгийн хөшүүргийг Засгийн газрын зүгээс оновчтой ашиглах шаардлагатай байна.

Түүнээс гадна эдийн засгийн өрсөлдөөний орчин бүрдээгүй нь инновацийн үйл явцын идэвхжилтэнд сөрөг нөлөө үзүүлж байна. Ганц нэг пүүс компани монополь байдлаар ажиллах биш, зах зээл дээр ижил төрлийн олон пүүс компаниуд үйлдвэрлэлийн техник, технологийг боловсронгуй болгож, бүтээгдэхүүгийн өртөг зардлыг хямдруулж, чанарыг сайжруулан өрсөлдөх нөхцлийг бий болгох шаардлагатай байгаа юм.

Тухайлбал БНСУ-д 1970-аад оны эхэнд шинжлэх ухааны судалгаа ба боловсруулалтын нийт зардлын 84 % нь улсын эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдэд, 3 % нь их сургуулиудад, 13 % нь пүүс компаниудад ноогдож байжээ. Гэтэл сүүлийн 40 – өөд жилд тус улсын Засгийн газраас хувийн томоохон пүүс компаниудын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих бодлого явуулснаар 2008 оны байдлаар нийт судалгаа боловсруулалтын зардлын 14 % нь улсын эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдэд, 11 % нь их сургуулиудад, 75 % нь пүүс компаниудад ноогдох болсон байна. (Хүснэгт № 6)

БНСУ-ын судалгаа ба боловсруулалтын зардлын бүтэц, 1970-2008
(санхүүжилтийн эх үүсвэрээр, хувиар)

Хүснэгт № 6

| Үзүүлэлтүүд | 1970 | 1980 | 1990 | 2000 | 2008 |
|---|-------|-------|-------|-------|-------|
| Нийт судалгаа ба боловсруулалтын зардал | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Улсын эрдэм шинжилгээний хүрээлэн | 84.0 | 49.0 | 22.0 | 15.0 | 14.0 |
| Их сургууль | 3.0 | 12.0 | 7.0 | 11.0 | 11.0 |
| Компани | 13.0 | 38.0 | 71.0 | 74.0 | 75.0 |

Эх үүсвэр : Ministry of Education, Science and Technology of Korea, each year, Survey on. 2009, Seoul

Ялангуяа пүүс компаниудын эрдэм шинжилгээ, судалгааны нийт зардлын 39 % нь “Hyundai Motors”, “Samsung Electronics”, “LG Electronics”, “Daewoo Corporation”, “Pohang Iron & Steel Corporation” зэрэг тус улсын тэргүүлэх таван компанид ноогдож байна.

Эндээс шинжлэх ухааны судалгаа боловсруулалтыг эрчимтэй хийж, дэлхийн зах зээлд өрсөлдөх, улс орныхоо экспортыг нэмэгдүүлэх, эдийн засгийн бүтцийг шинэчлэхэд томоохон пүүс компаниудын гүйцэтгэх үүрэг асар их болох нь харагдаж байна.

Ингэж эрдэм шинжилгээ, судалгааны зардлын санхүүжилтийн гол хэсэг хувийн хэвшилд шилжсэнээр улсын төсвийн зардал хэмнэгдэхийн зэрэгцээ шинжлэх ухааны судалгаа, боловсруулалтын ажлын үр дүн эрс нэмэгдэж, түүнийг үйлдвэрлэлд түргэн шуурхай нэвтрүүлэх, үндэсний томоохон пүүс компаниудын дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, ажиллах хүчнийг богино хугацаанд мэргэшүүлэх зэрэг олон давуу талтай байна. Ийм арга хэмжээний үр дүнд шинжлэх ухаан, технологийн орчин үеийн ололт, амжилтыг ашиглаж үйлдвэрлэсэн зарим бүтээгдэхүүгийн үйлдвэрлэлтээр БНСУ дэлхийд дээгүүр байр эзлэх болсон байна. Тухайлбал тус улс 2008 оны байдлаар дэлхийн зах зээл дэх ялтсан санах ой багтаамжийн үйлдвэрлэлийн 50 %, шингэн кристалл дэлгэцийн үйлдвэрлэлийн 46 %, CDMA-ийн үйлдвэрлэлийн 38%, усан онгоцны үйлдвэрлэлийн 37 %, автомашин үйлдвэрлэлийн 5 %, гангийн үйлдвэрлэлийн 4 % -ийг тус тус үйлдвэрлэж байна. Эдгээр нь бүгд дээр дурьдсан тус улсын тэргүүлэх компаниудын үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн юм. Гэхдээ үүнд төр засгийн дэмжлэг туслалцаа, хувийн хэвшлийн идэвх чармайлтын аль аль нь чухал гэдэг нь тодорхой.

Тиймээс манай Засгийн газраас юуны өмнө дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд :

- Дунд ба урт хугацааны хэтийн төлөвтэй шинжлэх ухаан техникийн дэвшил, инновацийн чиглэлтэй, ирээдүйтэй салбар, үйлдвэрлэлийг нарийвчлан тодорхойлох, эрдэм шинжилгээ, судалгааны салбарт, ялангуяа үндэсний чадварлаг боловсон хүчнийг бэлтгэхэд чиглэсэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ;

- Эрүүлийг хамгаалах, анагаах ухаан, хүнсний аж үйлдвэр, мал аж ахуй–газар тариалан зэрэг улс орны үндэсний аюулгүй байдлыг хангах, аж ахуйн уламжлалт хэвшлийг хадгалах, хөгжүүлэхэд чиглэгдсэн биотехнологийн судалгааг эрчимжүүлэх ;
- Орчин үеийн аж үйлдвэрийн парк, технологийн төвүүдийг байгуулах, түүнд тулгуурлан байгаль цаг уурын шинэ нөхцөлд тохирсон эдийн засгийн салбаруудыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг орчин үеийн техник технологи бүхий жижиг, дунд үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэхэд чиглүүлэх ;
- Засгийн Газрын 2007 оны 306 тоот тогтоолоор баталсан “Монгол улсад Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр 2008 – 2015” –д заасан дэвшилтэт технологийг хөгжүүлэхтэй холбогдсон хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлэх ;
- Суурь болон хавсарга судалгааг гүйцэтгэж байгаа эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага ба төвүүд, эрдэмтдийн судалгааны үр дүнг томоохон пүүс компаниудын судалгаа, боловсруулалтын ажилтай уялдуулах, хамтарсан судалгааг дэмжих, үйлдвэрлэлд шууд нэвтрүүлэх арга замыг тодорхойлох зэрэг болно.

Абстракт

Монгол улсын эдийн засагт оруулж буй нийт хөрөнгө оруулалтын хэмжээ зах зээлд шилжсэн сүүлийн 20 гаруй жилд олон дахин нэмэгдсэнийг статистикийн тоо баримт харуулж байна. Гэтэл манай ард түмний аж амьдрал ядуу, эдийн засгийн хөгжлийн түвшин доогуур хэвээр, өнөөг хүртэл эдийн засгийн оновчтой бүтэц бүрэлдээгүй, орчин үеийн техник технологи бүхий жижиг дунд үйлдвэрлэл бараг хөгжөөгүй, экспортод уул уурхай, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд зонхилсон хэвээр байна.

Иймээс жил ирэх тутам өсөн нэмэгдэж буй төсвийн орлогын эх үүсвэрийг Монгол орны өвөрмөц онцлог, байгаль цаг уурын шинэ нөхцөл байдал, дэлхийн шинжлэх ухаан-техникийн дэвшлийг харгалзсан эдийн засгийн салбарыг хөгжүүлэх, ийм салбарт хамаарах орчин үеийн техник технологи бүхий жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шууд чиглүүлэх шаардлагатай байна. Үүнд нөлөөлөх олон хүчин зүйл байгаа нь тодорхой бөгөөд энэхүү өгүүлэлд улс ба хувийн секторын ялангуяа томоохон пүүс компаниудын шинжлэх ухааны судалгаа ба боловсруулалт, инновацийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, энэ чиглэлээр оруулж буй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, түүний үр ашгийг дээшлүүлэх асуудалд анхаарал хандуулахыг зорьсон болно.

Жич : Энэхүү судалгааг хийхэд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлсэн БНСУ-ын ахисан түвшний судалгааны сан (KFAS), МУИС-ийн дэргэдэх Азийн судалгааны төв (ARC) –ийн хамт олон, удирдлагад гүн талархал илэрхийлье.